



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Шинэ коронавирусийн халдварын
болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх,
бэлэн байдлыг хангах тухай

2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын албан ёсны мэдээгээр шинэ коронавирусийн халдвараар 232 хүн өвчилж, 6 хүн нас барсан ба Тайландын Вант Улсад 2, Япон улс, БНСУ-д тус тус 1 тохиолдол зөөвөрлөгдсөн байна.

Мөн АНУ, Австрали, Филлипин улсад өвчлөл бүртгэгдсэн тухай албан бус мэдээлэл байна. БНХАУ-д эрүүл мэндийн ажилтнууд өвчлөлд өртөж, агаар дуслын замаар халдвар дамжих эрсдэлтэй байгааг тогтоогоод байна.

Иймд шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тандалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган ажиллахыг ДААЛГАСУГАЙ. Үүнд:

Нэг. Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д:

1. Шинэ коронавирусийн халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл, нөхцөл байдалд тухай бүр эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зохион байгуулах;

2. Эрсдэлийн зэрэгт үндэслэн шуурхай удирдлагын нэгжийн үйл ажиллагааг идэвхжлийн горимд шилжүүлэн ажиллах;

3. Шинэ коронавирусийн талаарх албан ба албан бус мэдээллийг шүүж, эрүүл мэндийн байгууллагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах;

4. Амьсгалын замын хүнд халдварын эмнэлэгт сууриласан тандалтыг эрчимжүүлж, хүнд хэлбэрийн тохиолдол бүрийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах;

5. Шуурхай хариу арга хэмжээний 3-4 багийг бэлтгэж сургах;

6. Цаг үеийн нөхцөл байдлын талаар цахим хурал тогтмол хийж, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

7. Мэдээлэл сурталчилгааны цуврал зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан тогтмол түгээх.

143200005

Хоёр. Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, ялангуяа тусгаарлах, эрчимт эмчилгээний тасгийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
2. Шинэ коронавирусийн эмнэлзүйн халдварын оношилгоо, эмчилгээний зөвлөх багийг томилон ажиллуулах;
3. ХӨСҮТ-ийн шинэ болон сэргэж буй халдварын тасгийн эмчилгээ үйлчилгээний бэлэн байдлыг хангах;
4. Шинэ коронавирусийн эмнэлзүй, оношилгооны чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг сургах.

Гурав. Эм үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д:

1. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, оношилгуур, урвалж, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдлыг хангах;
2. Эрүүл мэндийн байгууллагын эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмжийн судалгааг гарган, бэлэн байдлыг хангах;
3. Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг гаргах;
4. Вирусийн эсрэг үйлчилгээтэй ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг гарган, бэлэн байдлыг хангах.

Дөрөв. Төрийн захиргааны удирдлагын газар/ Б.Цогтбаатар/, Эрүүл мэндийн хөгжлийн төв/ Б.Нарантуяа/-д:

1. Шаардлагатай үед нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч мэргэжилтэн, эмнэлгийн ажилтны судалгааг гаргаж сургалтад хамруулах;
2. Анагаахын чиглэлээр суралцаж буй резидент эмч, төгсөх ангийн оюутны судалгааг гарган, дайчлан ажиллуулах төлөвлөгөө гаргах;
3. Шинэ коронавирусийн тандалт, эрт илрүүлэг оношилгоо, эмчилгээ, халдварын хяналт, сэргийлэлтийн талаар эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах.

Тав. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д:

1. Шинэ коронавирусийн талаарх хүн амын дундах ойролцоо хандлагыг тандаж, тухай бүр нь хариу арга хэмжээ авах;
2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд тандалт судалгаа мониторинг хийж, тухай бүр нь тайлбар, залруулга, мэдээлэл хийж байх;

3. Эрсдэлийн харилцаа холбоог эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган түгээх.

Зургаа. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар:

1. “Хүний Коронавируст халдварын тандалт, оношилгоо, эмчилгээ, халдвараас сэргийлэх” заавар батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2015 оны 242 дугаар тушаал, ДЭМБ-ын түр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах /Зөвлөмжийг хавсаргав/;

2. Амьсгалын замын халдварын тандалтыг эрчимжүүлж, хүнд хэлбэрийн тохиолдол бүрийг ХӨСҮТ-д мэдээлж, лабораторийн шинжилгээнд сорьц илгээн оношийг баталгаажуулах;

3. Үйлчлүүлэгч бүрийг амны хаалт зүүлгэх нөхцөлөөр ханган хэвшүүлэх;

4. Амьсгалын замын халдвартай үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх замын зураглал гаргаж, үйлчлүүлэгчдийн урсгал хөдөлгөөнд зохицуулалт хийх, халдвараас сэргийлэх, халдвар хяналтын дэглэмийг баримтлах;

5. Тусгаарлах болон эрчимт эмчилгээний тасаг, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

6. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын дархлааг дэмжих, амин дэмээр хангах зэрэг арга хэмжээг авах;

7. Орон нутгийн хил, гааль, мал эмнэлэг, мэргэжлийн хяналтын байгууллагатай мэдээллийг шуурхай солилцон, хариу арга хэмжээг зохион байгуулах;

8. Хилийн нэвтрэн орох цэгтэй аймгууд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран зорчигчдод зөвлөмж өгч ажиллах.

Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг 14 хоног тутам гарган Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргад ирүүлж байхыг холбогдох газар хэлтсийн дарга, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар даалгасугай.

САЙД



Д. САРАНГЭРЭЛ